



“ХҮРД” ХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
Б.ЭНХЖАРГАЛ ТАНАА

## “БЭСТ ФОРТУНА АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо  
“Урбанек” ХХК-ийн байр 307 тоот  
Утас: 324338, 98056465,  
89116465, 98006465  
И-мэйл: fortune2009audit@gmail.com

2021. 02. 22 № 22

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

#### **Зөрчилгүй дүгнэлт**

Бид “Хүрд” ХК-ийн 2021 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон эдгээр тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Монгол улсын Сангийн сайдын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн хувьд баримталсан зарчим, сонгож хэрэглэсэн арга, дотоод хяналтын системийг судлав. Санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэл бүхий нотолгоо олж авах зорилгоор аудитын түүврийн болон бусад арга горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.


#### **Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаа зөрчилгүй бэлтгэж, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, шударгаар толилуулахтай холбоотой, зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ. Засаглал хариуцсан этгээдүүд санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

#### **Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний зорилго бол ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм.

ЗАХИРАЛ  Ж. ОЮУНЦЭЦЭГ



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ**

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЛБАН ЁСНЫ НЭР: "ХҮРД" ХК		Санхүүгийн тайлангийн өдөр: 2021.12.31	
<b>ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ</b>			
Д/Д	САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ГҮЙЦЭТГЭЛ / мянган төгрөг /	
		Аудитлагдаагүй	Аудитлагдсан
	<b>А. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	14,203,725.4	14,203,725.4
2	Дансны авлага	6,796,827.1	6,796,827.1
3	Татвар, НДШ-ийн авлага	1,663.3	1,663.3
4	Бусад санхүүгийн хөрөнгө	179,439.1	179,439.1
5	Бараа материал	1,052,397.2	1,052,397.2
6	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,257,790.2	1,257,790.2
7	Бусад эргэлтийн хөрөнгө	5,500.0	5,500.0
	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>23,497,342.3</b>	<b>23,497,342.3</b>
	<b>Б. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		
1	Үндсэн хөрөнгө	1,285,070.7	1,285,070.7
2	Биет бус хөрөнгө	394.9	394.9
	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,285,465.6</b>	<b>1,285,465.6</b>
	<b>ХӨРӨНГИЙН НИИТ ДҮН</b>	<b>24,782,807.9</b>	<b>24,782,807.9</b>
	<b>В. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
1	Дансны өглөг	4,644,091.5	4,644,091.5
2	Татварын өр	848,447.5	848,447.5
3	Ногдол ашгийн өглөг	8,007.8	8,007.8
4	Урьдчилж орсон орлого	3,045,091.2	3,045,091.2
5	Бусад богино хугацаат өр төлбөр	176.3	176.3
	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>8,545,814.3</b>	<b>8,545,814.3</b>
	<b>Г. УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
1	Урт хугацаат зээл		
	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИИТ ДҮН</b>	<b>8,545,814.3</b>	<b>8,545,814.3</b>
	<b>Д. ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
1	Хувийн өмч	736,097.9	736,097.9
2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	164,937.0	164,937.0
3	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	15,335,958.7	15,335,958.7
	<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>16,236,993.6</b>	<b>16,236,993.6</b>
	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>24,782,807.9</b>	<b>24,782,807.9</b>
	<b>ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН</b>		
1	Борлуулалтын орлого	19,509,518.0	19,509,518.0
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	14,717,144.5	14,717,144.5
3	Түрээсийн орлого	62,713.7	62,713.7
4	Хүүгийн орлого	401,184.0	401,184.0
5	Бусад орлого	26,567.2	26,567.2
6	Ерөнхий ба удирдлагын зардал	227,706.3	227,706.3
7	Бусад зардал	452,960.8	452,960.8
9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(2,203.1)	(2,203.1)
10	<b>ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ/АЛДАГДАЛ/</b>	<b>4,599,968.2</b>	<b>4,599,968.2</b>
11	Татварын зардал	505,292.9	505,292.9
12	Татварын дараах ашиг (алдагдал)	4,094,675.3	4,094,675.3
	<b>ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ/</b>	<b>4,094,675.3</b>	<b>4,094,675.3</b>
	<b>ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН</b>		
1	Хувийн өмч	736,097.9	736,097.9
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	164,937.0	164,937.0
2	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	15,335,958.7	15,335,958.7
	<b>НИИТ ДҮН</b>	<b>16,236,993.6</b>	<b>16,236,993.6</b>
	<b>МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН</b>		
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	28,733,531.1	28,733,531.1
2	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	25,426,618.1	25,426,618.1
	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ</b>	<b>3,306,913.0</b>	<b>3,306,913.0</b>
	<b>ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НИИТ ДҮН</b>	<b>3,306,913.0</b>	<b>3,306,913.0</b>
	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ</b>	<b>10,896,812.4</b>	<b>10,896,812.4</b>
	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН</b>	<b>14,203,725.4</b>	<b>14,203,725.4</b>

Нэмэлт тодотголууд нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

